

**Англи хэлний ойролцоо утгатай нэр томьёог монгол хэлнээ оноох асуудалд
(Стандартчилсан нэр томьёоны жишээгээр)**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Намсрайн МӨНХЦЭЦЭГ*

*Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар*

Received: May 15, 2024

Revised: August 08, 2024

Accepted: October 18, 2024

Хураангуй: Энэхүү судалгаанд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар болон Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны хамтран бүрдүүлсэн 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолт бүхий хөмрөгийг хэрэглэгдэхүүн болгон ашигласан болно. Дээрх хөмрөгөөс англи нэр томьёо бүхий 32 стандартад англи хэлний хоёр ба түүнээс дээш нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон 50 тохиолдол байна. Тэдгээрийг жишээ баримтаар баяжуулан тайлбарлаж, алдааг хэрхэн засаж залруулах талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно. Дээрх 50 тохиолдлоос салбар дотор буюу нэг стандартад англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо нэр томьёог монгол хэлэнд нэг нэр томьёогоор оноосон 30 тохиолдол байна.

Стандарт, тэр дундаа нэр томьёоны стандарт цэгцрээгүй байх нь ухагдахууныг төөрөгдөл үүсгэх сөрөг талтай. Буруу оноосон, оновчгүй нэр томьёог стандартчилснаар хэрэглэгчдэд шинэ мэдлэг, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар буруу таашаа ойлголт өгч, аливаа салбарт үл ойлголцол үүсэх, түүнээс үүдсэн эдийн засгийн үр ашиггүй зардал бий болох шалтгаан болдог. Тиймээс нэр томьёоны стандартуудыг нарийвчлан судалж, шаардлага хангахгүй, буруу оноосон нэр томьёог засаж, сайжруулан стандартыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна.

Түлхүүр үг: стандартчилсан нэр томьёо, ойролцоо нэр томьёо, орчуулга, ухагдахуун, хам бичвэр, үүрэг

* © Н.Мөнхцэцэг, 2024

Email: munkhtsetsegn@mas.ac.mn,  <https://orcid.org/0000-0001-5285-0566>

On Translation of English Synonymous Terms into Mongolian (With Examples of Standardized Terms)

MUNKHTSETSEG Namsrai

Department of Applied Linguistics, the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The study utilizes a corpus of 10,387 terms and definitions from 85 standards developed by the Institute of Language and Literature at the Mongolian Academy of Sciences (MAS) in collaboration with the Office of the National Council for Language Policy. There are 50 instances where two or more synonymous English terms are translated into a single term in Mongolian. These instances can be illustrated with examples and suggestions for correcting errors. Of these 50 cases, 30 involve cases where multiple English terms are translated as one term in Mongolian within a specific subject field or standard.

Using incorrect or imprecise terminology can lead to misunderstandings regarding new knowledge, products, and services intended for consumers, which can ultimately result in unnecessary economic costs. Therefore, it is crucial to thoroughly review and update terminology standards to correct any inaccuracies.

Keywords: standardized terms, synonymous terms, translation, concept, context, function

1. Удиртгал

Аливаа стандартад шинжлэх ухаан, техник технологийн ойлголт ухагдахууныг зөв ойлгож танин мэдэхэд хэл найруулгын алдаагүй, зөв оновчтой нэр томьёо, тодорхойлолт, тэмдэг, тайлбар, жишээ чухал ач холбогдолтой. Иймээс олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд нэр томьёог стандартчилдаг. Нэр томьёоны стандартыг шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл үйлчилгээнээс гадна өдөр тутмын ерөнхий хэрэглээнд зориулан боловсруулдаг. Үндсэндээ нэр томьёоны стандартчилал нь салбар дотор, салбар хооронд, бүс нутагт, үндэсний хэмжээнд, олон улсын түвшинд мэргэжлийн харилцааг хялбарчилж, үр дүнтэй болгодог. Гэхдээ аливаа стандартыг боловсруулах, орчуулах, үндэсний болгох, тэр дундаа нэр томьёог стандартчилах нь нарийн төвөгтэй хэцүү ажил юм. Учир нь аливаа салбарын нэр томьёог стандартчилахад тухайн салбарын болон хэл шинжлэл, нэр томьёо судлалын мэдлэг, туршлагатай мэргэжилтэн шаардлагатайгаас гадна салбар доторх, салбар хоорондын, үндэсний, цаашилбал олон улсын хамтын ажиллагаа чухал юм. Тухайлбал, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг стандартчилахдаа түүнтэй холбоотой нэр томьёог давхар стандартчилах шаардлага тулгардаг.

Шинжлэх ухаан, техник технологи эрчимтэй хөгжиж буй даяаршлын өнөө үед шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын стандартыг орчуулж, үндэсний

болгоход хамгийн түрүүнд тулгарах асуудал бол тухайн стандарт дахь нэр томьёог монгол хэлнээ орчуулж оноох асуудал юм. Үнэн хэрэгтээ нэр томьёоны орчуулга нь орчуулга биш, харин сурвалж хэлний нэр томьёонд дүйх үгийг зорилтот хэлний үгийн сангаас хайх үйл явц, өөрөөр хэлбэл “хүлээн авагч хэл ба үгийн сангийн ухагдахууны тогтолцоо дахь ижил ухагдахууныг олж илрүүлэх явдал юм” (Ачкасов, 2013). Нэр томьёог орчуулахад орчуулагчид тулгардаг хамгийн гол асуудал бол үгийн оноолт юм (Лейчик, 1990). Ялангуяа гадаад хэлний ойролцоо утгатай нэр томьёонуудын утгын ялгаа, хэрэглээний онцлогийг илэрхийлж, орчуулж буй хэлэнд тохирох дүйцлийг олж онооно гэдэг бол хамгийн нарийн төвөгтэй ажил гэдгийг шинжлэх ухааны салбар бүрийн нэр томьёоны хос ба олон хэлний толь бичгүүдээс харж болно. Хэлний тэмдэг буюу нэрлэлт өөр байна гэдэг нь түүнийг тэмдэглэгдсэн ухагдахуун өөр байна гэсэн үг юм. Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болох стандартчилсан нэр томьёонд англи хэлний ойролцоо утгатай нэр томьёоны утгын нарийн ялгааг гаргалгүй монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон тохиолдол олон байна. Энэ нь олон ухагдахууныг нэг ухагдахуун мэт ойлгох, үүнээс үүдэн мэргэжлийн харилцаанд төөрөгдөл үүсэх, цаашилбал, нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж магадгүй юм.

Монгол хэлний ойролцоо үгийн талаар бичсэн судалгааны бүтээл олон байгаа боловч гадаад хэлний ойролцоо үг, нэр томьёог орчуулах талаар бичсэн бүтээл ховор байна. Иймд бид энэхүү өгүүлэлдээ Монгол Улсын нэр томьёоны стандартууд дахь англи хэлний ойролцоо утгатай нэр томьёонуудыг монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон асуудлыг жишээ баримтаар авч үзэн тэдгээрийн утгын ялгааг гаргаж хэрхэн оноох талаар саналаа дэвшүүлэх болно.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар болон Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба хамтран бүрдүүлсэн 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолт бүхий хөмрөгийг хэрэглэгдэхүүн болгон ашигласан болно. Хөмрөгөөс англи нэр томьёотой стандартуудыг ангилан тоон шинжилгээ хийж, англи хэлний хоёр ба түүнээс дээш нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор орчуулж оноосон тохиолдлыг жишээ баримтаар баяжуулан тайлбарлаж, алдааг хэрхэн засаж залруулах талаар өөрийн саналыг бичсэн. Ингэхдээ англи хэлний ойролцоо нэр томьёонуудыг нэг нэр томьёогоор оноосон жишээг бүртгэн давтамж ихтэй зарим нэр томьёог утга, хэрэглээ, үүргийн талаас нь харьцуулж хүснэгтлэн үзүүлэв.

Мөн нэг мэргэжлийн салбар буюу нэг стандартад англи хэлний ойролцоо утгатай олон нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон тохиолдлыг бүртгэн тоог нарийвчлан гаргаж, зарим жишээг хүснэгтээр үзүүлсэн болно.

3. Ойролцоо нэр томьёоны орчуулгын тухай онолын үндэслэл

Хэл шинжлэлд “мөнхийн” сэдвүүдийн нэг болох ойролцоо нэрийн асуудал орчуулга судлал, нэр томьёо судлалд ч шийдэгдээгүй, нарийн төвөгтэй үзэгдэл бөгөөд монгол хэл шинжлэлд “synonym” хэмээх нэр томьёог олон янзаар оноож нэрлэсээр ирсэн байна. Тухайлбал, ойролцоо нэр (Лувсанвандан нар, 1966; Өлзийхутаг, 1979), ойролцоо үг (Бадамдорж, 1997; Баянсан, 1995; Бат-Ирээдүй, 1998; Базаррагчаа., Мөнгөнцэцэг нар, 2012), ойролцоо утгатай үг (Төмөрцэрэн, 1964, 1974; Отгонсүрэн, 1998; Сүхбаатар, 2009) гэх мэт. “Монгол хэл судлал” хэмээх 15 боть бүтээлийн “Үгийн сан, утга зүй” хэмээх X ботид “ойролцоо утгатай үг” хэмээн нэрлээд а) үгийн сангийн ойролцоо утгатай үг, б) үнэмлэхүй ойролцоо утгатай үг, в) найруулгын ялгаат ойролцоо утгатай үг, г) хэлэхүйн буюу хам сэдвийн ойролцоо утгатай үг (2022: 161) хэмээн ангилжээ. Энэхүү өгүүлэлд бид ойролцоо нэр томьёоны тухай ерөнхийд нь авч үзэхийг зорьсонгүй, харин англи хэлний ойролцоо утгатай нэр томьёог монгол хэлнээ хэрхэн орчуулж, оноосныг стандартчилсан нэр томьёоны жишээгээр авч үзэхийг зорьсон билээ. Орчуулга судлаач Нида ойролцоо утгатай үгийг “хэд хэдэн (гэхдээ бүгдийг нь биш) чухал бүрэлдэхүүн хэсгээр нийтлэг, зарим (гэхдээ бүгд биш) нөхцөл байдалд мэдэгдэхүйц ялгаагүйгээр бие биеэ орлож болох үгс” (1969: 73) гэж тодорхойлсон байдаг.

Нэр томьёог оноон боловсруулахад баримтлах нэг зарчим бол нэр томьёо нэг утгатай байх, нэгдмэл байх явдал юм. К.Ж.Дунне¹ “Нэгдмэл байх” (consistency) зарчмын хувьд техникийн баримт бичигт үндсэн гурван төрлийн алдаа гарч болно” гээд дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

- буруу нэр томьёо (жишээ нь, тухайн ухагдахууныг нэрлэхэд буруу нэр томьёо хэрэглэсэн тохиолдолд);
- нэгдмэл бус нэр томьёо (жишээ нь, нэг ухагдахууныг нэрлэхэд өөр өөр нэр томьёо хэрэглэх үед); болон
- хоёрдмол утгатай нэр томьёо (жишээ нь, нэг нэр томьёогоор нэгээс олон ухагдахууныг нэрлэх үед) (2007: 34)

Дээрхээс бид гуравдугаар асуудал буюу монгол хэлний нэг нэр томьёогоор англи хэлний нэгээс олон ухагдахууныг нэрлэж буй тохиолдлыг авч үзэх болно. Тодруулбал, англи хэлнээс нэр томьёог монгол хэлнээ орчуулахдаа тухайн нэр томьёогоор илэрч буй ухагдахуун, ухагдахууны тогтолцоо, харьцаа хийгээд түүнтэй ойролцоо утгатай нэр томьёоноос ялгагдах онцлог зэргийг нарийн судлалгүйгээр зөвхөн тухайн үгийн нэрлэлтийг өнгөц авч үзсэнээр ухагдахууны хувьд хоорондоо нарийн ялгаатай олон нэр томьёог нэг нэр томьёогоор оноох тохиолдол их байна.

Ойролцоо утгатай нэр томьёо нь тухайн нэр томьёо боловсруулагч, орчуулагчдын хэл, соёл, сэтгэхүйн онцлог нэгэн бүтээгдэхүүн тул нэг хэлнээс

¹ Dunne, K. J

нөгөө хэлэнд утга ялган орчуулах амаргүй байдаг нь хэлний тэмдэгтийн ялгах ба адилтгах үүрэгтэй холбоотой юм. Ялангуяа хийсвэр ухагдахуун заасан ойролцоо утгатай үг, нэр томьёоны утгын нарийн ялгааг гарган орчуулах нь орчуулагчаас өргөн хүрээний мэдлэг, чадвар шаарддаг бөгөөд нэр томьёоны тогтолцоотой байх зарчмыг хангахад тустай.

Нэг хэлний ойролцоо утгатай нэр томьёо нөгөө хэлэнд дүйцэлтэй эсвэл дүйцэлгүй байж болно. Энэ бол нэр томьёог орчуулахад тулгардаг гол бэрхшээлийн нэг юм. Тухайлбал үнэмлэхүй ойролцоо нэр нь бие биеэ орлож чадахуйц байдаг бөгөөд нэг ухагдахууныг нэрлэсэн Британийн ба Америкийн англи хэлний хувилбар байж болно. Жишээ нь: *investor*, *stockholder*, *shareholder*, *bondholders* гэсэн нэр томьёо нь үнэмлэхүй ойролцоо нэр томьёо юм. Тодруулбал, *investor* гэдэг нэр томьёо нь Британийн англи хэл, Америкийн англи хэлний аль алинд 1. Хөрөнгө буюу капитал оруулагч хүн, 2. Үнэт цаасыг эзэмшигч гэсэн утгыг илэрхийлдэг бол харин Британийн англи хэлэнд *shareholder*, Америкийн англи хэлэнд *stockholder* гэдэг хоёр нэр томьёо нь хөрвөх хөрөнгө эзэмшигч гэсэн ижил ухагдахууныг нэрлэдэг байна. Дээрх ойролцоо нэр томьёонууд нь ерөнхий (*hypernym*), тусгай (*hyponym*) харьцаатай. Ер нь ихэнх ойролцоо үг төрөл ба харьяа утгатай байдаг. Тэгэхээр *stockholder (shareholder)* - бүрэн ойролцоо нэр томьёо нь *investor* буюу *хөрөнгө оруулагч* гэсэн ерөнхий нэрийн багтаах харьцаанд багтана. Мөн *bondholder* гэдэг нэр томьёо нь багтах харьцаатай. Тусгай харьцаанд буй дээрх нэр томьёонууд нь харилцан бие биеэ орлох боломжтой. Энэ мэтчилэн ойролцоо утгатай нэр томьёог зарим тохиолдолд бие биеийг орлуулж болох боловч бүх тохиолдолд орлуулах боломжгүй юм. Учир нь ерөнхий-тусгайн харьцаа, найруулгын өнгө аяс, хам сэдэв, хэрэглээний орчин зэргээс шалтгаалан утга тохирохгүй байх нь их. Тиймээс зорилтот хэлэнд тэдгээрийг дүйцүүлэн орчуулахад бэрхшээлтэй байдаг. Ойролцоо нэр томьёог орчуулахад орчуулгын хэд хэдэн үндсэн ойлголт, зарчмыг анхаарах ёстой. Үүнд:

- Утгын дүйцэл: Энэ зарчим нь зорилтот хэлэнд сурвалж хэлний нэр томьёоны утгыг хадгалсан дүйцлийг олоход чиглэдэг. Англи хэлний аливаа нэр томьёог орчуулахдаа тухайн нэр томьёогоор илэрсэн ухагдахууны тогтолцоо хийгээд бусад ойролцоо утгатай нэр томьёоноос ялгагдах онцлог шинжийг харгалзан монгол хэлнээ дүйх үгийг олох;
- Хам сэдэв: Ойролцоо нэр томьёоны утга нь хам сэдвээс хамаарч өөр өөр байж болно. Тиймээс тухайн нэр томьёог хэрэглэж буй хам сэдвийг харгалзан үзэж, дүйцлийг олох (Дашдаваа, Равдан., 1980: 55);
- Соёлын хамаарал: Ойролцоо нэр нь шууд орчуулах боломжгүй соёлын онцлог шинжийг хадгалсан байж болно. Соёлын онцлогийг ойлгож мэдэх нь орчуулагчдад зорилтот хэрэглэгчдэд тохирсон нэр томьёог сонгоход тустай (Бэкер², 1992: 26)

² Baker, M

- Хам орчин ба хэв маяг: Ойролцоо нэр томьёог янз бүрийн түвшний харилцаанд хэрэглэхээс шалтгаалан өөр өөр нэрлэлттэй байж болно. Тухайлбал, албан ёсны харилцаанд уу, энгийн харилцаанд уу, мэргэжлийн харилцаанд уу гэдгээс шалтгаалан өөр өөр байж болно.
- Үүргийн дүйцэл: Энэ зарчим нь бичвэр доторх нэр томьёоны үүргийг чухалчилдаг. Тодруулбал, ойролцоо нэр томьёоны тус тусын үүргийг судалж зөв дүйцлийг олох;
- Динамик ба хэлбэрийн дүйцэл: Динамик дүйцэл нь ерөнхий утга санаа, найруулгын өнгө аясыг илэрхийлэхэд чиглэдэг бол хэлбэрийн дүйцэл нь илүү шууд, үг бүрээр орчуулах (Нида³, 1964: 21)-ыг хэлнэ. Англи хэлний ойролцоо нэр томьёог орчуулахдаа хэлбэрийн дүйцлээс илүү динамик дүйцлийг олох нь чухал юм. Эдгээр онол, зарчмыг ойлгох нь ойролцоо нэр томьёог нөхцөл байдал, хэрэглээ, хам сэдэвт тохируулан үнэн зөв, орчуулахад тустай юм.

4. Ойролцоо нэр томьёоны орчуулгад хийсэн задлан шинжлэл

Энэ хэсэгт бид дээр дурдсан судалгааны хэрэглэгдэхүүнээс англи орчуулгатай нэр томьёоны стандартыг ялгаж үзвэл нийт 85 стандартаас 32 нь англи нэр томьёотой стандарт байна. Тэдгээрээс англи хэлний ойролцоо утгатай хоёр ба түүнээс дээш нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон 50 тохиолдол байна. Үүнийг Хүснэгт 1-д тоймлон үзүүлж, англи хэлний ойролцоо нэр томьёонуудыг нэг нэр томьёогоор оноосон жишээг бүртгэн дэлгэрэнгүй хүснэгтээр ХАВСРАЛТ-д үзүүлэв.

Хүснэгт 1. Англи хэлний ойролцоо утгатай хоёр ба түүнээс дээш нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон жишээ

№	Англи хэлний нэр томьёо		Жишээ
1	2 нэр томьёо	19	income, revenue – орлого
2	3 нэр томьёо	16	zone, area, space – бүс
3	4 нэр томьёо	5	certification, proving, validation, verification – баталгаажуулалт
4	5 нэр томьёо	3	analysis, review, assessment, research, test – шинжилгээ
5	6 нэр томьёо	4	warranty, assurance, certificate, validation, approval, guarantee - баталгаа
6	9 нэр томьёо	2	check, testing, control, surveillance, supervision, monitoring, audit, inspection – хяналт
7	10 нэр томьёо	1	criterion, index, indicator, characteristic, criteria, measure, characterization, indication factor - үзүүлэлт

³ Nida, E.

Хүснэгт 1-ээс харахад, англи хэлний 2 ба 3 нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон хамгийн их хувь эзэлж байна. Тэдгээрээс давтамж ихтэй зарим нэр томьёог утга, хэрэглээ, үүргийн талаас нь харьцуулж хүснэгтлэн үзүүлэв. Тухайлбал, бидний судалгааны хэрэглэгдэхүүнд англи хэлний *evaluation*, *assessment* гэсэн хоёр нэр томьёог *үнэлгээ* гэж нэг нэр томьёогоор оноосон байна.

Жишээ нь:

(1) А. *safety assessment* - аюулгүйн үнэлгээ (MNS 4673: 1998)

Б. *type (pattern) evaluation* - загварын үнэлгээ (MNS OIML V 1:2009) гэх мэт.

Англи хэлний *assessment*, *evaluation* гэсэн хоёр нэр томьёо нь хэдийгээр ойролцоо утгатай боловч ухагдахууны хувьд ялгаатай. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Англи хэлний *assessment*, *evaluation* хэмээх хоёр нэр томьёоны харьцуулалт

Харьцуулалтын шалгуур үзүүлэлт	assessment	evaluation
Утга	одоогийн гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор өгөгдөл цуглуулах, хянах, ашиглах үйл явц	стандартын үндсэн дээр дүгнэлт гаргах үйлдэл
Хэрэглээ	тухайн хүний гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлохын тулд хийгддэг	зорилгодоо хүрэх түвшнийг тодорхойлохын тулд хийгддэг
Мөн чанар	оношлох	шүүн тунгаах
	гүйцэтгэл болон сайжруулах чиглэлийн талаар санал	зорилгодоо хэр хүрч байгааг тодорхойлдог.
Зорилго	хөгжүүлэх	нэгтгэн дүгнэх
Чиглэл	үйл явцад чиглэсэн	бүтээгдэхүүн буюу үр дүнд чиглэсэн
Талуудын харилцаа	тусгах	зааварчлах
Хариу үйлдэл	ажиглалт, эерэг ба сөрөг талууд дээр үндэслэсэн.	тодорхой стандартын дагуу чанарын түвшинд үндэслэсэн
Шалгуур	хоёр тал хамтран тогтооно	шалгагч тогтооно
Хэмжих стандарт	үнэмлэхүй	харьцангуй

Эх сурвалж: <https://keydifferences.com/difference-between-assessment-and-evaluation.html>

Дээрх хүснэгтээс үзэхэд, *assessment* гэсэн нэр томьёог *үнэлгээ* хэмээн оноож, харин *evaluation*-ийг *үнэлэлт* *дүгнэлт* гэсэн хоршоо үгээр оноох нь зүйтэй санагдаж байна.

Мөн *responsibility*, *liability*, *obligation* гэсэн гурван нэр томьёог *хариуцлага* гэж нэг нэр томьёогоор оноосон олон тохиолдол байна. Жишээ нь:

- (2) А. *constructive obligation* - үүсмэл хариуцлага (MNS 5242: 2003)
 Б. *liability of the carrier* - тээвэрлэгчийн хариуцлага (MNS 6387-4 : 2016)
 В. *obligation* - хариуцлага (MNS 5242: 2003) гэх мэт оноожээ.

Дээрх гурван нэр томьёо буюу ухагдахууны адил ба ялгаатай шинжийг Хүснэгт 3-т авч үзье.

Хүснэгт 3. Англи хэлний *responsibility, liability, obligation* хэмээх нэр томьёоны харьцуулалт

Харьцуулалтын шалгуур үзүүлэлт	responsibility	liability	obligation
Тодорхойлолт	Аливаа зүйлтэй харьцах үүрэгтэй байх эсвэл хэн нэгнийг хянах нөхцөл байдал, баримт	Буруутай үйлдэл, хайхрамжгүй хандсан тохиолдолд хуулийн өмнө хүлээх санхүүгийн хариуцлага	Ёс суртахууны болон хуулийн дагуу хийх ёстой үйлдэл, үйл ажиллагааны чиглэл
Утга	Таны хийх ёстой, хүлээгдэж буй үүрэг, даалгавар	Хохирол барагдуулах	Хувь хүн ёс суртахууны болон хуулийн дагуу хүлээсэн үүрэг
Хүчин зүйл	Гаднын хүчин зүйлээс болон өөрөө өөртөө оногдуулсан байж болно.	Бусдад хор хохирол учруулсны улмаас гаднаас шаардсан хуулийн хариуцлага	Ихэвчлэн хууль, гэрээ, нийгмийн хэм хэмжээ гэх мэт гаднын хүчин зүйлээс шалтгаалдаг
Хүрээ	Өргөн, ёс зүйн ойлголт	Тодорхой, хязгаарлагдмал, хуулийн ойлголт	Тодорхой, хязгаарлагдмал
Мөн чанар	Сайн дурын шинжтэй байж болно.	Заавал биелүүлэх ёстой	Заавал биелүүлэх ёстой үүрэг
Зорилго	Ажил үүрэг биедээ хүлээх	Бусдад хор хохирол учруулсных нь төлөө хариуцлага хүлээлгэх	Хувь хүн, аж ахуйн нэгжийн биелүүлэх ёстой үүрэг, хариуцлагын мэдрэмжийг бий болгох
Чиглэл	Гадаад хүчин зүйл	Дотоод хүчин зүйл	Дотоод хүчин зүйл
Хариу үйлдэл	Хуулийн хүрээнд	Санхүүгийн	Ёс суртахууны хүрээнд

Эх сурвалж: <https://www.askdifference.com/responsibility-vs-liability/>

Хүснэгт 3-аас үзэхэд, *responsibility* гэдэг үгийг *хариуцлага*, *liability* гэдэг үгийг *өр төлбөр*, *obligation* гэдэг үгийг *үүрэг* гэж утга ялган оноох нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн англи хэлний *ability*, *capability*, *capacity* гэсэн ойролцоо утгатай үгсийг монгол хэлнээ утга ялгалгүйгээр *чадвар* хэмээх үгээр дүйлгэсэн тохиолдол бидний судалгааны хэрэглэгдэхүүнд нэлээд байна. Тухайлбал:

(3) А. *assimilation capacity* - *ус шингээх чадвар* (MNS 6279: 2011)

covering capacity - *хучих чадвар* (MNS ISO 9229: 2010)

railway carrying capacity - *төмөр замын тээх чадвар* (MNS 6387-4: 2016)

Б. *capability* - *хүчин чадал, чадвар* (MNS ISO 6701-1: 2010)

preserving capability - *ажиллах чадвараа хадгалах шинж* (MNS 3831: 2003)

В. *service ability* - *ашиглагдах чадвар, үйлчлэх чадвар* (MNS ISO 6701-1: 2010) гэх мэт олон жишээг дурдаж болно.

Англи хэлний *ability*, *capacity*, *capability* нь “near synonym” буюу “дөхүү ойролцоо утгат үгс”-ийн жишээ бөгөөд тэдгээрийг энгийн хэлнээс гадна олон салбар шинжлэх ухаанд нэр томъёоны үүргээр түгээмэл хэрэглэдэг. Хэдийгээр англи хэлэнд бүгдийг нь аливаа үйлдлийг гүйцэтгэх хүчийг илэрхийлэхэд хэрэглэдэг боловч тэдгээр нь үүргийн хувьд ялгаатай ухагдахууныг тэмдэглэнэ. Тэдгээрийн ялгааг цахим сурвалжуудаас судлан үзээд дараах байдлаар тоймлож байна. Үүнд:

Ability: Энэ нэр томъёо нь хувь хүний эзэмшсэн ур чадвараас гадна программ хангамжийн бодит ур гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг. Аливаа туршлагад тулгуурлан тухайн хүн, техник хэрэгсэл юу хийж чадахыг онцолдог. Жишээлбэл, тухайн нэг программ хангамж өгөгдлийг үр дүнтэй боловсруулах чадвартай байж болно. Товчоор хэлбэл, *ability* = одоо байгаа бодит ур чадвар эсвэл функц. Иймээс монгол хэлний *чадвар* хэмээх нэр томъёотой дүйнэ.

Capacity: Энэ нэр томъёо нь ямар нэг техник хэрэгслийн чадварын дээд хэмжээ буюу хязгаарыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, тухайн техник хэрэгслийн хүчин чадлыг хэлдэг. Жишээлбэл, Энэхүү машины моторын хүчин чадлын тухай ярихад хэрэглэнэ. Товчоор хэлбэл, *capacity* = хамгийн дээд хязгаар. Иймээс монгол хэлний *хүчин чадал* гэдэг нэр томъёотой дүйнэ.

Capability: Энэ нэр томъёо нь илүү өргөн хүрээтэй бөгөөд тодорхой чиг үүрэг, даалгавруудыг гүйцэтгэх программ хангамж болон техникийн боломжит чадварыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, зөвхөн одоо байгаа чадвар төдийгүй хөгжүүлэх, сайжруулах боломжийг агуулдаг. Жишээлбэл, программ хангамжийн функцийг өргөтгөх, улам сайжруулах боломжтой байж болно. Товчоор хэлбэл, *capability* = ирээдүйн боломжуудыг багтаасан боломж ба чиг үүргийн хүрээ. Иймээс монгол хэлний *чадамж* хэмээх нэр томъёотой дүйлгэж болно.

Энэхүү ялгааг эш үндэс болгон, дээрх жишээг дахин нягталж үзвэл, MNS 6387-4: 2016 Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо,

тодорхойлолтод буй *railway carrying capacity* гэсэн англи нэр томьёог монгол хэлнээ *төмөр замын тээх чадвар* гэж орчуулсан байна. Энэ нэр томьёоны тодорхойлолт нь “*Жилийн турш тухайн шугамаар тээвэрлэж болох ачааны дээд хэмжээ*” гэжээ. Тэгэхээр *төмөр замын тээх чадвар* гэхийн оронд *төмөр замын тээх хүчин чадал* (даац) гэж орчуулах нь зүйтэй юм. Түүнчлэн *preserving capability*-ажиллах чадвараа хадгалах шинж гэсэн нэр томьёо нь “*Объектын тогтоосон нөхцөлд тээвэрлэх, хадгалах хугацааны турш ажиллах чадвар, бүрэн байдлаа тасралтгүй хадгалах шинж*” гэсэн тодорхойлолттой байна. Тодорхойлолтоос үзвэл, *ажиллах чадвараа хадгалах шинж* гэхийн оронд *тасралтгүй ажиллах чадамж* гэж оноох нь тохиромжтой байна.

Судалгааны явцад бидний ажигласан бас нэг чухал зүйл бол салбар дотор буюу нэг стандартад англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо нэр томьёог монгол хэлэнд нэг нэр томьёогоор оноосон 30 тохиолдол байна. Тэдгээрээс заримыг Хүснэгт 4-д үзүүлье.

Хүснэгт 4. Нэг стандартад англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо нэр томьёог монгол хэлэнд нэг нэр томьёогоор оноосон жишээ

	Стандарт	Англи нэр томьёо	Монгол оноолт
1	MNS 0515: 2015 Шуудан холбооны нэр томьёо	<i>mail</i>	<i>шуудан</i>
		<i>post</i>	
		<i>postage</i>	
		<i>dispatch</i>	
2	MNS 5242 : 2003 Нягтлан бодох бүртгэл - нэр томьёо, тодорхойлолт	<i>revenue</i>	<i>орлого</i>
		<i>income</i>	
3	MNS ISO 6701-1: 2010 Барилга ба иргэний барилга байгууламж	<i>bay</i>	<i>тавцан</i>
		<i>deck</i>	
		<i>flange</i>	
		<i>sill</i>	
4	MNS ISO 9229: 2010 Дулаан тусгаарлах материал	<i>panel</i>	<i>хавтан</i>
		<i>boardslab</i>	
		<i>slab</i>	
5	MNS 6387-1: 2013 Төмөр зам. Зам. Замын аж ахуйн нэр томьёо, тодорхойлолт	<i>audit</i>	<i>хяналт</i>
		<i>control</i>	
		<i>monitoring</i>	
6	MNS 3831: 2003 Техникийн найдвартай ажиллагаа	<i>parameter</i>	<i>үзүүлэлт</i>
		<i>index</i>	

Хүснэгт 4-өөс харахад, зарим стандартад англи хэлний 2-4 нэр томьёог монгол хэлэнд нэг томьёогоор оноосон байна. Жишээ нь: MNS 0515: 2015 Шуудан холбооны нэр томьёоны стандартад англи хэлний *mail*, *post*, *postage*, *dispatch* гэсэн 4 нэр томьёог *шуудан* гэсэн нэг томьёогоор; MNS ISO 6701-1: 2010

Барилга ба иргэний барилга байгууламжийн нэр томьёоны стандартад *bay, deck, flange, sill* гэсэн 4 нэр томьёог *тавцан* гэсэн нэг нэр томьёогоор тус тус оноосон байна⁴. Түүнчлэн MNS 5242: 2003 “Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо” стандартад англи хэлний *revenue*: “Байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт хэлбэрээр илэрсэн, эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм”; *income*: “Эдийн өмчийг нэмэгдүүлснээр хөрөнгийн хэмжээг өсгөх болон өр төлбөрийг багасгах байдлаар бүртгэлийн жилийн туршид эдийн засгийн өгөөж нэмэгдэх” гэсэн хоёр өөр тодорхойлолт бүхий нэр томьёог орлого гэсэн нэр томьёогоор дүйлгэсэн байна. Өөрөөр хэлбэл, хоёр өөр ухагдахууныг монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон байна. Дээрх хоёр тодорхойлолт болон англи толь бичгийн тодорхойлолтуудыг харьцуулж үзвэл, *revenue* гэдэг нь нийт орлогыг хэлдэг бол, *income* гэдэг нь цэвэр орлогыг хэлдэг ажээ.

5. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Бид судалгааны үр дүнд нэр томьёоны стандартуудад англи хэлний ойролцоо нэр томьёог хэрхэн оноон хэрэглэж буй талаар дараах зүйлийг олж илрүүллээ. Үүнд:

1. Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болох 85 стандартын 32 нь англи нэр томьёотой байна.
2. Дээрх 32 стандартад англи хэлний ойролцоо утгатай хоёр ба түүнээс дээш нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон 50 тохиолдол байна.
3. Тэдгээр ойролцоо нэр томьёог ажиглавал, ихэвчлэн салбарын дундын шинжтэй буюу шинжлэх ухааны ерөнхий нэр томьёо байна.
4. Тэдгээр 50 тохиолдлыг задалж үзвэл, англи хэлний 2 нэр томьёо (19), 3 нэр томьёо (16), 4 нэр томьёо (5), 5 нэр томьёо (3), 6 нэр томьёо (4), 9 нэр томьёо (2), 10 нэр томьёо (1)-г тус бүр нэг монгол нэр томьёогоор оноосон байна. Эдгээрээс хамгийн их буюу англи хэлний *criterion, index, indicator, characteristic, criteria, measure, characterization, indication, factor* гэсэн 10 ойролцоо утгатай нэр томьёог монгол хэлнээ *үзүүлэлт* гэсэн нэг нэр томьёогоор оноосон байна.
5. Дээрх 50 тохиолдлоос салбар дотор буюу нэг стандартад англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо нэр томьёог монгол хэлэнд нэг нэр томьёогоор оноосон 30 тохиолдол байна.
6. Бид монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон, давтамж ихтэй зарим ойролцоо нэр томьёог харьцуулж үзвэл, хэдийгээр ухагдахууны гол шинжээрээ төстэй боловч үүрэг, зорилго, чиглэл, хам сэдэв, ухагдахууны хүрээний хувьд өөр хоорондоо нарийн ялгаатай болохыг олж илрүүллээ.

⁴ Жишээ болгож авсан зарим нэр томьёо нь нийлэмж үгийн бүрэлдэхүүнд байсан. Тухайлбал, *electronic mail* – *электрон шуудан, loading bay* – *ачих тавцан* гэх мэт.

7. Ийнхүү харьцуулан судалсны дүнд жишээлж авсан зарим англи ойролцоо нэр томьёог монгол хэлээр хэрхэн ялган оноох талаар өөрсдийн саналыг дараах байдлаар дэвшүүлсэн болно. Үүнд: 1. *assessment* - үнэлгээ, *evaluation* - үнэлэлт дүгнэлт; 2. *responsibility* - хариуцлага, *liability* - өр төлбөр, *obligation* - үүрэг; 3. *ability* - чадвар, *capacity* - хүчин чадал (даац), *capability* - чадамж; 4. *revenue* - нийт орлого, *income* - цэвэр орлого. Бидний санал болгож буй энэхүү оноолтуудыг судалгааны хэрэглэгдэхүүн болох стандартын хүрээнд тогтоосон боловч дээр дурдсанчлан эдгээр нэр томьёо нь салбар дундын шинжтэй, шинжлэх ухааны ерөнхий нэр томьёо тул аль ч шинжлэх ухааны салбарт нэгэн адил хэрэглэж болно гэж үзэж байна.
8. Англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосноос гадна нэг нэр томьёог монгол хэлэнд олон нэр томьёогоор оноосон тохиолдол судалгааны явцад ажиглагдсан. Энэ удаагийн судалгааны зорилго бол англи хэлний ойролцоо утгатай нэр томьёонуудыг нэг нэр томьёогоор оноосон тохиолдлыг судлах байсан тул энд авч үзсэнгүй.
9. Цаашид ойролцоо утгатай нэр томьёоны орчуулгыг утгын ангилал, хам бичвэр, үүргийн талаас нь илүү өргөн хүрээнд нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд бидний энэ судалгаа суурь болно.

6. Дүгнэлт

Бид энэ удаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй 85 нэр томьёоны стандартын 10387 нэр томьёо бүхий сангаас англи нэр томьёотой стандартуудыг сонгон авч, тэдгээрээс англи хэлний хоёр ба түүнээс дээш ойролцоо утгатай нэр томьёог монгол хэлнээ нэг нэр томьёогоор оноосон тохиолдлыг түүвэрлэн судалж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Нэр томьёог орчуулна гэдэг нь зөвхөн зорилтот хэлний үг зүй, авиа зүйн хэлбэрийг харгалзсан дүйцэлт үгийг олох тухай асуудал бус харин нэр томьёо, ухагдахуун хоёрын харьцаа буюу утгын асуудлыг анхаарах хэрэгтэй. Судалгаанаас үзэхэд, нэр томьёоны орчуулгад гарч буй түгээмэл нэг алдаа нь англи хэлний ойролцоо нэр томьёонуудыг орчуулахдаа ухагдахууны нарийн ялгааг дутуу гаргаж монгол хэлэнд нэг нэр томьёогоор оноосон асуудал юм.
- Стандарт, тэр дундаа нэр томьёоны стандарт өөрөө цэгцрээгүй байх нь төөрөгдөл үүсгэх сөрөг талтай. Буруу оноосон, оновчгүй нэр томьёог стандартчилснаар хэрэглэгчдэд шинэ мэдлэг, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар буруу ташаа ойлголт өгч, аливаа салбарын хэмжээнд үл ойлголцол үүсэх, түүнээс үүдсэн эдийн засгийн үр ашиггүй зардал бий болох шалтгаан болдог.
- Англи хэлний ойролцоо утгатай нэр томьёонуудын утгын нарийн ялгааг гаргахын тулд тэдгээрийг өөр хооронд нь харьцуулан судалж, нэр томьёоны гол шалгуур болох тогтолцоот байх зарчмыг баримтлах хэрэгтэй. Тодруулбал, нэр томьёог орчуулахдаа дан дангаар бус, тухайн

ухагдахуун буюу нэр томьёотой ерөнхий - тусгай (төрөл нэр томьёо), бүхэл - хэсэг (харьяа нэр томьёо), уялдаат⁵, ойролцоо - эсрэг харьцаанд буй бусад нэр томьёотой хамтад нь авч үзэхээс гадна тэдгээрийн үүрэг, хэрэглээ, хам бичвэр зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр монгол хэлний өөр өөр үгээр оноох хэрэгтэй. Ийнхүү монгол үгээр оноохдоо мөн хоёр хэлний нэр томьёоны утгын хамаарлыг тодруулсны дараа ямар нэр томьёог сонгохоо шийдэх нь зүйтэй.

- Мөн ойролцоо утгатай англи, монгол ойролцоо утгатай нэр томьёоны сан бүрдүүлж, тайлбар толь бичиг зохиох нь дээр дурдсан олон асуудлыг шийдэх нэг гарц болно гэж үзэж байна.

Талархал

Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (хуучнаар)-ны санхүүжилтээр хэрэгжиж буй [ШУТБИХХЗГ-2022/196] Монгол нэр томьёоны стандартын судалгаа (Нэр томьёо боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах) төслийн хүрээнд бичсэн судалгааны нэг хэсэг юм.

Ном зүй

- Ачкасов, А.В.** (2013). *Основы двуязычной терминографии для переводчиков. Учебное пособие для студентов, обучающихся на переводческих программах бакалавриата и магистратуры (английский язык)*. Издательство Санкт-Петербургского университета.
- Бадамдорж, Д.** (1997). *Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс*. Улаанбаатар: Сүхбаатар ХХК. [Badamdorj, D. *Orchin tsagiin mongol khelnii utga sudlalyn undes* [Fundamentals of modern Mongolian semantics]. Ulaanbaatar: Sükhbaatar LLC. 1997]
- Базаррагчаа, М., Мөнгөнцэцэг, Б нар.** (2012). Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн, мэдэхүүн ба хэлэгдэхүүн, хэлэхүүний талаас үзэх нь. *Монгол судлал* сэтгүүл, XXXIV (360), Улаанбаатар, х.13-27 [Bazarragchaa, M., Möngöntsetseg, B. Concerning Mongolian synonyms in terms of language and speech. *Mongolian studies journal*, 2012, 360: 13-27]
- Бат-Ирээдүй, Ж.** (1998). *Монгол хэлний ойролцоо утгат үг хэллэгийн бүтэц, утга, үүргийн судалгаа*. Улаанбаатар [Bat-Ireedüi, J. *Mongol khelnii oiroltsoo utgat üg khellegiin бүтэц, утга, үүргийн судалгаа* [A study of the structure, meaning, and function of Mongolian synonyms]. Ulaanbaatar. 1998]
- Баянсан, Ж., Одонтөр, Ш нар.** (1995). *Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь*. Хөх хот: Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо [Bayansan, J., Odontör, Sh. *Khel shinjleliin ner tomyony züilchilsen тайлбар толь* [Glossary of Mongolian linguistic terms]. Khökh khot: Inner Mongolia University Press. 1995]
- Дашдаваа, Д., Равдан, Э.** (1980). *Нэр томьёоны тухай*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэлийн газар [Dashdavaa, D., Ravdan, E. *Ner tomyonii tuhai* [On terminology]. Ulaanbaatar: Mongolian Academy of Science Publishing. 1980]

⁵ Associative relationship (ISO 704: 2024)

- Лейчик, В.М.** (1990). Лингвистические проблемы терминологии и научно-технический перевод [Текст] / В.М. Лейчик, С.Д. Шелов. – М.: Всесоюзный центр переводов, 80 с.
- Лувсанвандан, С., Сумьяабаатар, Б нар.** (1966). *Монгол хэлний ойролцоо үгийн товч толь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо [Luvsanvandan, S., Sumyabaatar, B. *Mongol khelnii oiroltsoo ügiin товч toli* [Concise dictionary of Mongolian synonyms]. Ulaanbaatar: Committee for State Press Affairs. 1966]
- Отгонсүрэн, Д.** (1998). *Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй*. Улаанбаатар: Адмон принт ХХК [Otgonsüren, D. *Mongol khelnii ügiin sangiin найруулга zui* [Mongolian lexicological stylistics] Ulaanbaatar: Admon print LLC. 1998]
- Өлзийхутаг, Ц.** (1979). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар: УХГ [Ölziikhutag, Ts. *Mongol khelnii ügiin sangiin судлал* [Mongolian lexicology]. Ulaanbaatar: State Publishing House. 1979]
- Сүхбаатар, Ц.** (2009). Ойролцоо үг хэллэг. *Монгол хэлний найруулга зүй*. х.332-339. [Sükhbaatar, Ts. Synonyms, Mongolian stylistics. *Mongol khelnii найруулга zui*, 2009, 332-339]
- Төмөрцэрэн, Ж.** (1964). *Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн хэвлэл [Tömörtseren, J. *Orchin tsagyn mongol khelnii ügiin sangiin судлал* [Modern Mongolian Lexicology]. Ulaanbaatar: Mongolian Academy of Science Publishing. 1964]
- Төмөрцэрэн, Ж.** (1974). *Монгол хэлний үгийн сан судлал*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл [Tömörtseren, J. *Mongol khelnii ügiin sangiin судлал* [Mongolian Lexicology]. Ulaanbaatar: Mongolian Academy of Science Publishing. 1974]
- Baker, M.** (1992). *In other words: A Course book on Translation*. London and New York: Routledge
- Dunne, K. J.** (2007). Terminology: ignore it at your peril. In: *Multilingual*, pp. 32-38
- Nida, E.** (1964). *Towards a Science of Translating*. Leiden: E.J. Brill.
- Nida, E & Taber Ch.R.** (1969). *The Theory and Practice of Translation*. Leiden: E.J. Brill.

Стандарт

- MNS 4673: 1998 *Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа*
- MNS 5242: 2003 *Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо*
- MNS 6387-4 : 2016 *Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт*
- MNS 6279: 2011 *Ус хангамж, ариун цэврийн байгууламж*
- MNS ISO 9229: 2010 *Дулаан тусгаарлах материал*
- MNS ISO 6701-1: 2010 *Барилга ба иргэний барилга байгууламж*
- MNS 3831: 2003 *Техникийн найдвартай ажиллагаа*
- MNS 0515: 2015 *Шуудан холбооны нэр томьёо*
- MNS 6387-1: 2013 *Төмөр зам. Зам. Замын аж ахуйн нэр томьёо, тодорхойлолт*


**ХАВСРАЛТ: АНГЛИ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО УТГАТАЙ НЭР ТОМЪЁОГ
МОНГОЛ ХЭЛНЭЭ НЭГ НЭР ТОМЪЁОГООР ОНООСОН ЖИШЭЭ**

- (1) Evaluation- Үнэлгээ (MNS ISO/TS 19104: 2012), Assessment- Үнэлгээ (MNS ISO 9001: 2016);
- (2) Responsibility- Хариуцлага (MNS ISO 9001: 2016), Liability- Хариуцлага (MNS 0515: 2015), (MNS 6387-4: 2016), Obligation- Хариуцлага (MNS 5242: 2003);
- (3) Property- Өмч, Equity- Өмч (MNS 5242: 2003);
- (4) Income- Орлого (MNS 0515: 2015), (MNS 5242: 2003), Revenue- Орлого (MNS 5242: 2003);
- (5) Profit- Ашиг (MNS 5242: 2003), Surplus- Ашиг (MNS 5401: 2004);
- (6) Charge- Төлбөр, Fee- Төлбөр (MNS 6387-4: 2016), Liability- Төлбөр, Settlement- Төлбөр (MNS 5242: 2003), Postage- Төлбөр, Payment- Төлбөр (MNS 0515: 2015);
- (7) Accident-Осол, Hazard- Осол (MNS 6010: 2016), (MNS 6279: 2011), (MNS 3475: 2003);
- (8) Baggage-Тээш, Luggage- Тээш (MNS 6387-4: 2016), (MNS 6387-3: 2013);
- (9) Transportation- Тээвэрлэлт (MNS ISO/TS 19104: 2012), (MNS 6387-4: 2016), Carriage- Тээвэрлэлт (MNS 6387-1: 2013), (MNS 6387-3: 2013), (MNS 6387-4: 2016), (MNS ISO 4306-1: 2010);
- (10) Item- Илгээмж, Parcel- Илгээмж (MNS 0515: 2015);
- (11) Cost- Зардал (MNS 0515: 2015), (MNS 5242: 2003), (MNS 6387-4: 2016), Expense- Зардал (MNS 5242: 2003);
- (12) Landslide- Газрын гулгалт (MNS 6010: 2016), (MNS 6387-1: 2013), Landslip- Газрын гулгалт (MNS 6010: 2016);
- (13) Warranty- Баталгаа (MNS 5242: 2003), (MNS 6387-1: 2013), Assurance- Баталгаа (MNS ISO 6701-1: 2010), Certificate- Баталгаа (MNS ISO 1998-5: 2008), Validation- Баталгаа (MNS 6279: 2011), (MNS ISO/TS 19104: 2012), Approval- Баталгаа (MNS OIML V 1: 2009), (MNS ISO 6701-1: 2010), Guarantee- Баталгаа (MNS 5242: 2003), (MNS 6387-4: 2016);
- (14) Port- Тавцан, Board- Тавцан (MNS ISO 1998-5: 2008), Flat- Тавцан (MNS 6387-3: 2013), Platform- Тавцан (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6387-4: 2016), (MNS ISO 4306-1: 2010), Dock- Тавцан, Pallet- Тавцан, Flap- Тавцан (MNS 0515: 2015), Deck- Тавцан (MNS ISO 6701-1: 2010);
- (15) Pipe- Хоолой (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 1998-5: 2008), (MNS 6279: 2011), (MNS 6387-1: 2013), Tube- Хоолой (MNS ISO 6701-1: 2010), (MNS 5086: 2001), (MNS ISO 1998-5: 2008), (MNS 6387-1: 2013), Throat- Хоолой (MNS 6387-1: 2013), (MNS ISO 3877-2: 2014);
- (16) Board- Хавтан (MNS ISO 8966: 2002), (MNS ISO 9229: 2010), (MNS ISO 6701-1: 2010), Slab- Хавтан (MNS ISO 9229: 2010), (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6387-1: 2013), Boardslab- Хавтан (MNS ISO 9229: 2010), Panel- Хавтан (MNS ISO 9229: 2010), (MNS 5086: 2001), Plate- Хавтан (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6387-3: 2013), (MNS ISO 17659: 2012);

- (17) Injury- Гэмтэл (MNS 3474: 2003), Damage- Гэмтэл (MNS 3831: 2003), (MNS ISO 3877-1: 2014), (MNS 4118: 1991), (MNS 6387-1: 2013), (MNS 6387-5: 2019), Failure- Гэмтэл (MNS 6387-1: 2013), Blemish- Гэмтэл, Break- Гэмтэл (MNS ISO 3877-1: 2014), Crack- Гэмтэл (MNS 6387-1: 2013);
- (18) Pressures- Ачаалал (MNS 6387-1: 2013), Load- Ачаалал (MNS 0515: 2015), (MNS 3831: 2003), (MNS 5085: 2001), (MNS ISO 1998-5: 2008), (MNS ISO 8930: 2001), (MNS 6387-1: 2013), (MNS 2919: 2003);
- (19) Hazard- Аюул (MNS 6010: 2016), (MNS 6279: 2011), (MNS 6387-5: 2019), Danger- Аюул (MNS 0515: 2015), (MNS 6387-1: 2013), (MNS 6387-4: 2016);
- (20) Zone- Бүс (MNS 4967: 2000), (MNS 6010: 2016), (MNS ISO 1998-6: 2008), (MNS 6279: 2011), (MNS 6387-1: 2013), Area- Бүс (MNS 6010: 2016), (MNS ISO 3877-1: 2014), (MNS 4673: 1998), (MNS ISO 1998-6: 2008), Space- Бүс (MNS ISO 6701-1: 2010);
- (21) Check- Хяналт (MNS 0515: 2015), (MNS 2980: 2003), (MNS ISO 6701-1: 2010), Testing- Хяналт (MNS 0515: 2015), Control- Хяналт (MNS OIML V 1: 2009), (MNS 0515: 2015), (MNS 5242: 2003), (MNS ISO 9229: 2010), (MNS ISO/TS 19104: 2012), (MNS 2980: 2003), (MNS 4673: 1998), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 1998-6: 2008), (MNS 6279: 2011), (MNS 3475: 2003), (MNS 6387-1: 2013), (MNS 6387-2: 2013), (MNS ISO 9001: 2016), Surveillance- Хяналт (MNS 4673: 1998), Proving- Хяналт (MNS ISO 1998-6: 2008), Supervision- Хяналт (MNS OIML V 1: 2009), (MNS 4118: 1991), Monitoring- Хяналт (MNS 6010: 2016), (MNS 6387-1: 2013), Audit- Хяналт (MNS 6387-1: 2013), Inspection- Хяналт (MNS 4967: 2000), (MNS OIML V 1: 2009);
- (22) Failure- Эвдрэл (MNS 3831: 2003), (MNS 6387-5: 2019), Damage- Эвдрэл (MNS 0515: 2015);
- (23) Parameter- Үзүүлэлт (MNS 3831: 2003), (MNS 2980: 2003), (MNS EN 13481-2: 2013), (MNS 2919: 2003), Criterion- Үзүүлэлт (MNS 3831: 2003), (MNS 6387-5: 2019), Index- Үзүүлэлт (MNS ISO 1998-1: 2008), (MNS 3831: 2003), Indicator- Үзүүлэлт (MNS ISO/TS 19104: 2012), Characteristic- Үзүүлэлт (MNS 2980: 2003), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ASTM E 284: 2008), Criteria- Үзүүлэлт (MNS 6010: 2016), (MNS 6279: 2011), Measure- Үзүүлэлт (MNS 6387-5: 2019), Characterization- Үзүүлэлт (MNS ISO GUIDE 30: 2005), Indication- Үзүүлэлт (MNS 0515: 2015), Factor- Үзүүлэлт (MNS ISO 3877-1: 2014);
- (24) Property- Шинж чанар (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 6701-1: 2010), Characteristic- Шинж чанар (MNS ISO 1998-2: 2008), (MNS ISO 10185: 2012);
- (25) Analysis- Шинжилгээ (MNS 2980: 2003), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 1998-5: 2008), (MNS 6279: 2011), (MNS 6387-5: 2019), (MNS ISO 9001: 2016), Review- Шинжилгээ (MNS ISO 9001: 2016), Assessment- Шинжилгээ (MNS 6010: 2016), Research- Шинжилгээ (MNS 5242: 2003), (MNS ISO 1998-2: 2008), Test- Шинжилгээ (MNS ISO 1998-2: 2008);
- (26) Experiment- Түршилт (MNS ISO 1998-6: 2008), Test- Түршилт (MNS ISO 3877-1: 2014), (MNS ISO 9229: 2010), (MNS ISO 1998-2: 2008), (MNS 3831: 2003), (MNS 5086: 2001), (MNS ISO 4306-1: 2010);

- (27) Certification- Баталгаажуулалт (MNS ISO 9229: 2010), (MNS ISO GUIDE 30: 2005), Validation- Баталгаажуулалт (MNS ISO/TS 19104: 2012), Proving- Баталгаажуулалт (MNS ISO 1998-6: 2008), Verification- Баталгаажуулалт (MNS OIML V 1: 2009);
- (28) Factory- Үйлдвэрлэл (MNS ISO 9229: 2010), Production- Үйлдвэрлэл (MNS 4967: 2000), (MNS 5242: 2003), (MNS ISO 9229: 2010), (MNS 3831: 2003), (MNS ISO GUIDE 30: 2005), (MNS ISO 9001: 2016), Industry- Үйлдвэрлэл (MNS 6387-4: 2016);
- (29) Capacity- Чадвар (MNS ISO 9229: 2010), (MNS 3831: 2003), (MNS ISO 9346: 2011), (MNS 6279: 2011), (MNS 6387-4: 2016), Ability- Чадвар (MNS 6387-1: 2013), (MNS ISO 6701-1: 2010), Capability- Чадвар (MNS 3831: 2003), (MNS ISO 6701-1: 2010);
- (30) Bale- Баглаа боодол (MNS ISO 10185: 2012), Package- Баглаа боодол (MNS ISO 1998-5: 2008), (MNS 6387-4: 2016), Packet- Баглаа боодол, Bundle- Баглаа боодол (MNS 0515: 2015), Batch- Баглаа боодол (MNS ISO 6701-1: 2010);
- (31) Post- Шуудан, Dispatch- Шуудан, Postage- Шуудан (MNS 0515: 2015), Mail- Шуудан (MNS 0515: 2015), (MNS 6387-3: 2013), (MNS ISO 2392-1: 1999);
- (32) Cost- Өртөг (MNS 0515: 2015), (MNS 5242: 2003), (MNS 6387-4: 2016), Value- Өртөг (MNS 5242: 2003);
- (33) Accuracy- Нарийвчлал (MNS ISO 1998-2: 2008), (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ASTM E 284: 2008), (MNS ISO GUIDE 30: 2005), Precision- Нарийвчлал (MNS ISO 1998-2: 2008), (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 6701-1: 2010);
- (34) Residual- Нөөц (MNS 6387-5: 2019), Resource- Нөөц (MNS 3831: 2003), (MNS 4118: 1991), (MNS ISO 2392-1: 1999), (MNS ISO 9001: 2016), Reserve- Нөөц (MNS 6279: 2011), (MNS 3474: 2003), (MNS 6387-1: 2013);
- (35) Consumption- Хэрэглээ (MNS 6279: 2011), (MNS 2919: 2003), Application- Хэрэглээ (MNS ISO 9229: 2010), (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 2392-1: 1999), Use- Хэрэглээ, Usage- Хэрэглээ (MNS 6279: 2011);
- (36) Inventories- Бараа (MNS 5242: 2003), Product- Бараа (MNS 4673: 1998), Goods- Бараа (MNS ISO 6701-1: 2010);
- (37) Protection- Хамгаалалт (MNS 4673: 1998), (MNS 6279: 2011), (MNS 6387-1: 2013), (MNS ISO 2392-1: 1999), Security- Хамгаалалт (MNS ISO 6701-1: 2010), Guard- Хамгаалалт (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6387-1: 2013), Preservation- Хамгаалалт (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 9001: 2016);
- (38) Equipment- Төхөөрөмж (MNS OIML V 1: 2009), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 1998-4: 2008), Utility- Төхөөрөмж (MNS ISO 1998-4: 2008), Device- Төхөөрөмж (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 1998-5: 2008), (MNS 6387-1: 2013), (MNS 6387-2: 2013), (MNS ISO 2392-1: 1999);
- (39) Consumer- Хэрэглэгч (MNS 2919: 2003), Customer- Хэрэглэгч (MNS 0515: 2015), (MNS 6279: 2011), (MNS ISO 9001: 2016), User- Хэрэглэгч (MNS 0515: 2015), (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 2392-1: 1999);
- (40) Delivery- Хүргэлт (MNS 0515: 2015), (MNS 3339: 1982), (MNS 6387-4: 2016);

- (41) Access- Зөвшөөрөл (MNS ISO 6701-1: 2010), Permission- Зөвшөөрөл (MNS 6279: 2011), Recognition- Зөвшөөрөл (MNS 5242: 2003), Authorization- Зөвшөөрөл (MNS 4673: 1998);
- (42) Labor- Хөдөлмөр (MNS 6387-1: 2013), (MNS 6387-4: 2016), Working- Хөдөлмөр, Occupation- Хөдөлмөр (MNS 4967: 2000);
- (43) Damage- Хохирол, Loss- Хохирол (MNS 6010: 2016);
- (44) Utilization- Ашиглалт (MNS 3831: 2003), (MNS 4118: 1991), Operation- Ашиглалт (MNS 0515: 2015), (MNS 6387-1: 2013), Use- Ашиглалт (MNS 5242: 2003), Exploitation- Ашиглалт (MNS 3831: 2003), Service- Ашиглалт (MNS ISO 6701-1: 2010), (MNS ISO 8930: 2001), Maintenance- Ашиглалт (MNS OIML V 1: 2009);
- (45) Transmission- Дамжуулалт (MNS ASTM E 284: 2008), Transfer- Дамжуулалт (MNS ISO/TS 19104: 2012);
- (46) Operation- Үйл ажиллагаа, Activity- Үйл ажиллагаа (MNS 5242: 2003), (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6387-1: 2013), (MNS 6387-4: 2016), Transaction- Үйл ажиллагаа (MNS 0515: 2015), (MNS ISO/TS 19104: 2012);
- (47) Error- Алдаа (MNS 0515: 2015), (MNS 5242: 2003), (MNS ISO 1998-6: 2008), (MNS 6387-5: 2019), (MNS ISO GUIDE 30: 2005), Deviation- Алдаа, Fault- Алдаа (MNS ISO 6701-1: 2010);
- (48) Trade- Худалдаа (MNS ISO 6701-1: 2010);
- (49) Waste- Хог хаягдал (MNS ISO 6701-1: 2010), (MNS 6279: 2011), Residue- Хог хаягдал, Garbage- Хог хаягдал (MNS ISO 6701-1: 2010);
- (50) Balance- Тайлан (MNS 6387-1: 2013), Statement- Тайлан, Report- Тайлан (MNS 5242: 2003), Report- Тайлан (MNS ISO/TS 19104: 2012), (MNS ISO GUIDE 30: 2005);



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.